

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 3 дугаар зорилгод “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ.” гэж, 3.3 дахь зорилтод “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.” гэж, тус зорилтыг хэрэгжүүлэх I үе шатны 2 дугаар хүрэх үр дүнд “Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшсөн байна.” гэж, 4.5 дахь зорилтод “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл” гэж заасан бөгөөд энэ хүрээнд татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах, татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлэх, бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тус тус тусгасан.

Монгол Улс анх 1998 оноос нэмэгдсэн өртгийн албан татварыг нэвтрүүлж, улмаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг 2007, 2015 онд шинэчлэн найруулснаас хойш 10 жил өнгөрсөн байна. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдлаас үүдэлтэйгээр төгрөгийн ханш суларч, инфляц, хүүгийн түвшин нэмэгдсэн тул хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг дэмжих тухай асуудал нэн чухал ач холбогдолтой болж байна.

Хуулийн шинэчлэлээс хойших хугацаанд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвт бий болоод байна. Түүнчлэн Монгол Улсад жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлбөрийн чадвар буурч, санхүүгийн дарамтад орж, улмаар бизнесийн тогтвортой байдлаа хадгалахад хүндрэл үүсэж байна.

Монгол Улсын Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 176 мянга орчим санал хүлээн авсан. Хэлэлцүүлгийн үр дүнд ирүүлсэн нийтлэг саналуудыг харгалзан татварын бодлогыг илүү уян хатан болгох, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах практик шаардлага үүсэж байна.

Дээрх үндэслэл, шаардлагын дагуу Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараах агуулгын хүрээнд боловсрууллаа. Үүнд:

1.Бичил, жижиг бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж олгох зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босгыг 400 сая төгрөг болгон нэмэгдүүлнэ.

2.Татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшин, үйл ажиллагааны цар хүрээг харгалзан дотоод болон импортын НӨАТ-ын төлбөрийг хоёр хүртэл сарын хугацаагаар хойшлуулах боломжийг бүрдүүлж, аж ахуйн нэгжийн мөнгөн урсгал, уян хатан байдлыг дэмжинэ.

Хуулийн төсөл батлагдсанаар бизнес эрхлэгчдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн ачааллыг бууруулах, бизнес идэвхжих, тэлэх бололцоог хангах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 3 дугаар зорилгод “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ.” гэж, 3.3 дахь зорилтод “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.” гэж, тус зорилтыг хэрэгжүүлэх I үе шатны 2 дугаар хүрэх үр дүнд “Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшсөн байна.” гэж, 4.5 дахь зорилтод “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 7.1-д “Бизнес эрхлэх орчныг сайжруулж, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, татварын болон гаалийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, Монгол Улс өрсөлдөх чадварын үзүүлэлтээр 50 орны нэг болно.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл” гэж заасан бөгөөд энэ хүрээнд татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах, татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлэх, бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тус тус тусгасан.

Монгол Улс анх 1998 оноос нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ыг нэвтрүүлж, улмаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг 2007, 2015 онд шинэчлэн найруулснаас хойш 10 жил өнгөрсөн байна. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдлаас үүдэлтэйгээр төгрөгийн ханш суларч, инфляц, хүүгийн түвшин нэмэгдсэн тул хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг дэмжих тухай асуудал нэн чухал ач холбогдолтой болж байна. Иймд иргэн, аж ахуйн нэгжүүдэд үүсэж буй хүндрэлийг шийдвэрлэх шаардлага бий болж буйтай холбоотойгоор тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн шинэчлэлээс хойших хугацаанд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвт бий болоод байна. Түүнчлэн Ойрх Дорнодод үүссэн геополитикийн нөхцөл байдал макро эдийн засгийн болон бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд гадаад орчноос үүдэлтэй эдийн засгийн

сөрөг нөлөөллийг бууруулах, үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, бизнес эрхлэгчдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих шаардлага тулгараад байна.

Монгол Улсад 2024 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 58 орчим хувь нь мөнгөн хөрөнгийн дутагдалтай, 29 хувь буюу 30 мянга гаруй аж ахуйн нэгж алдагдалтай ажилласан нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлбөрийн чадвар буурах, санхүүгийн дарамтад орох, улмаар бизнесийн тогтвортой байдлаа хадгалахад хүндрэл үүсгэж байгааг харуулж байна. Иймд дээрх нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор татварын бодлогын холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 38 дугаар зүйлд заасны дагуу улс орон даяар бүх нийтийг хамарсан өргөн хүрээний хэлэлцүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлүүлж, татвар төлөгч, эрдэмтэн судлаач, худалдааны танхим зэрэг бүх талын оролцоог хангуулан нээлттэй санал авч, фокус группийн судалгааг хийсэн. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар, Эдийн засгийн хөгжлийн зөвлөлтэй хамтран улс орон даяар, давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 176 мянга гаруй саналыг хүлээн авсан.

Хэлэлцүүлгийн үр дүнд нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босгыг нэмэгдүүлэх, бизнесийн идэвхжилийг дэмжих, татвар төлөлтийг уян хатан болгох зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн байна.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараах агуулгын хүрээнд боловсрууллаа. Үүнд:

1.Бичил, жижиг бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж олгох зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босгыг 400 сая төгрөг болгон нэмэгдүүлнэ.

2.Татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшин, үйл ажиллагааны цар хүрээг харгалзан дотоод болон импортын НӨАТ-ын төлбөрийг хоёр хүртэл сарын хугацаагаар хойшлуулах боломжийг бүрдүүлж, аж ахуйн нэгжийн мөнгөн урсгал, уян хатан байдлыг дэмжинэ.

Хуулийн төсөл батлагдсанаар бизнес эрхлэгчдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн ачааллыг бууруулах, бизнес идэвхжих, тэлэх бололцоог хангах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.